



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

Автотээврийн болон өөрөө явагч  
хэрэгслийн албан татвар,  
агаарын бохирдлын төлбөр, авто зам  
ашигласны төлбөр хураах  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэг, Нийслэлийн засаг даргын "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/226 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийг бүрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөрөө хуулийн хугацаанд төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, аж ахуй нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох эрчимжүүлсэн хяналтын үзлэг, шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг тогтоосон хугацаанд хөнгөн шуурхай, татвар төлөгчдөд чирэгдэлгүй, нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан зохион байгуулж, хууль тогтоомжийн дагуу холбогдох төсөвт төвлөрүүлэн ажиллахыг Ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

4. Албан татвараа хуулийн хугацаанд төлөөгүй, албан журмын даатгал, техникийн үзлэгт хамрагдаагүй авто тээврийн хэрэгсэлд тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Тээврийн Цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Чингэлтэй дүүргийн замын Цагдаагийн хэлтэс (Г.Золжаргал)-т даалгасугай.

5. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажилд харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд дүүрэг дэх Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн холбогдох албан тушаалтнуудыг дайчлан, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүрэг дэх Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх)-т үүрэг болгосугай.

1505010742

6.Хорооныхоо нутаг дэвсгэрт төлбөр хураах, техник хяналтын үзлэгт хамруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох байгууллагуудтай ажлаа уялдуулан хамтран зохион байгуулж ажиллахыг 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7.Албан татвар, төлбөр хураах ажлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж сурталчлан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Т.Батцэцэг), дүүргийн Татварын хэлтэс (Н.Туул)-т тус тус үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
2025 оны 03 сарын 23 өдрийн  
1179 дугаар захирамжийн хавсралт

АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ  
ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР, АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨР,  
АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

	З.Бямбажав	Засаг даргын орлогч
Гишүүд:	Г.Энхбаяр	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дарга
	Т.Батцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Амгалан-Энх	Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын дарга
	Г.Золжаргал	Тээврийн цагдаагийн албаны харьяа Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга
	Н.Туул	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн дарга
	Ц.Алтанцацрал	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн Хувь хүний татварын тасгийн дарга

1-24 дүгээр хороодын Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

	Б.Төрмөнх	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн Хувь хүний татварын тасгийн татварын улсын байцаагч
--	-----------	--